

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 22 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны долдугаар сарын 09-ний өдрийн 14 цаг 06 минутад эхэлж, 15 цаг 57 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 51 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p> <ul style="list-style-type: none">- Нийслэлд зохион байгуулсан мэргэшлийн шалгалтын дүн- Сүхбаатар, Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Говьсүмбэр, Орхон, Сэлэнгэ, Өмнөговь, Хэнтий, Дундговь, Дархан-Уул аймагт зохион байгуулсан мэргэшлийн шалгалтын дүн- Эрүүл мэндийн яам, Боловсрол шинжлэх ухааны яам, Төрийн өмчийн хороо, Үндсэн хуулийн цэц, УИХ-ын Тамгын газрын сул орон тоог нөхөх мэргэшлийн шалгалтын дүн	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд Архангай, Сүхбаатар, Баянхонгор, Хөвсгөл, Говьсүмбэр, Сэлэнгэ, Орхон, Өмнөговь, Хэнтий, Дундговь, Дархан-Уул аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 07 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <ol style="list-style-type: none">1. Архангай, Сүхбаатар, Баянхонгор, Хөвсгөл, Говьсүмбэр, Сэлэнгэ, Орхон, Өмнөговь, Хэнтий, Дундговь, Дархан-Уул аймагт 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 240 иргэнээс 175 иргэн /Архангай аймагт 1, Сүхбаатар аймагт 9, Баянхонгор аймагт 11, Хөвсгөл аймагт 4, Говьсүмбэр аймагт 23, Сэлэнгэ аймагт 10, Орхон

		<p>аймагт 11, Өмнөговь аймагт 25, Хэнтий аймагт 61, Дундговь аймагт 6, Дархан-Уул аймагт 14/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 65 иргэн /Архангай аймагт 3, Сүхбаатар аймагт 1, Баянхонгор аймагт 1, Хөвсгөл аймагт 18, Сэлэнгэ аймагт 12, Өмнөговь аймагт 3, Хэнтий аймагт 8, Дундговь аймагт 4, Дархан-Уул аймагт 15/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 37, 38, 39, 40 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 66 иргэн /Архангай аймагт 1, Сүхбаатар аймагт 8, Баянхонгор аймагт 4, Хөвсгөл аймагт 3, Говьсүмбэр аймагт 8, Сэлэнгэ аймагт 8, Орхон аймагт 6, Өмнөговь аймагт 3, Хэнтий аймагт 14, Дундговь аймагт 5, Дархан-Уул аймагт 6/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 38 иргэн /Архангай аймагт 2, Сүхбаатар аймагт 1, Баянхонгор аймагт 1, Хөвсгөл аймагт 10, Сэлэнгэ аймагт 6, Өмнөговь аймагт 2, Хэнтий аймагт 8, Дундговь аймагт 3, Дархан-Уул аймагт 5/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 21-40 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 104 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг</p>
--	--	--

баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Архангай, Сүхбаатар, Баянхонгор, Хөвсгөл, Говьсүмбэр, Сэлэнгэ, Орхон, Өмнөговь, Хэнтий, Дундговь, Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлд тус тус үүрэг болгох.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 07 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд Нийслэлд зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 07 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

1. Нийслэлд 2014 оны 07 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 51 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх.

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 5 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.

3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 5 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөл /Ё.Гэрэлчулуун/-д үүрэг болгох.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 07 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 07 дугаар сарын 9-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :

1. Улсын Их Хурлын Тамгын газар, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Төрийн өмчийн хорооны сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 57 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх.

2. Энэхүү тогтоолын нэг дэх

		<p>хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 17 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.</p> <p>5. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 17 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тус тусын албан тушаалд томилохыг тухайн эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгох</p> <p>3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Удирдах албан тушаалд томилуулахаар санал болгох зарим албан тушаалтанд Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Зохион байгуулалтын газрын дарга 	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Хурцын Оюунцэцэгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар</p>

		<p>ТОГТОВ.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Лувсандоржийн Оюунчимэгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Зохион байгуулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Зарим хүмүүсийг "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах тухай	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан нэр бүхий 57 төрийн албан хаагчдыг Монгол Улсын “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Зам тээврийн яамны газрын даргаар ажиллаж байсан Д.Батбаатараас	Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлаас халах тухай”

	<p>гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 205 дугаар тушаалыг эс зөвшөөрч тус яамны Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар ажиллаж байсан Д.Батбаатараас Төрийн албаны зөвлөлд гаргасан гомдол үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1; 39.5 болон Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.4-ын “В”-д заасныг удирдлага болгон:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлаас халах тухай” 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 205 дугаар тушаал хууль зүйн үндэслэлгүй байна гэж үзсэн” Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх 2. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлаас халах тухай” 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 205 дугаар тушаалыг хүчингүй болгон шийдвэрлэхийг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батзаяад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
5	<p>Татварын ерөнхий газрын дэд даргаар ажиллаж байсан Ч.Жигжидээс гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>“Ч.Жигжидийг ажлаас чөлөөлөх тухай” Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 86 дугаар тушаалыг эс зөвшөөрч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Татварын ерөнхий газрын дэд дарга асан Ч.Жигжидээс Төрийн албаны зөвлөлд гаргасан гомдол үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан</p>

		<p>хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 болон Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 5-ийн 4-т заасныг удирдлага болгон:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Ч.Жигжидийг ажлаас чөлөөлөх тухай” Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 86 дугаар тушаал хууль зүйн үндэслэлгүй байна гэж үзсэн” Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх. 2. “Ч.Жигжидийг ажлаас чөлөөлөх тухай” Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 86 дугаар тушаалыг хүчингүй болгон хуульд нийцүүлэн шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Улаанд уламжлах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ